



AMCHAM

POSITION PAPER

МОНГОЛ УЛСЫН СЭРГЭЭГДЭХ
ЭРЧИМ ХҮЧНИЙ АГШИН:
БОЛОМЖИЙГ ЭРЧИМ ХҮЧ
БОЛГОН ХУВИРГАХ НЬ

Энэхүү баримт бичгийг **Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (AmCham)** нь **Energy Working Group** - ийн дэмжлэгтэйгээр бэлтгэлээ. Энэхүү хэвлэлийн бүх эрх нь AmCham-д хамаарна. Тайлангийн аль ч хэсгийг зохих зөвшөөрлөөр хуулбарлаж болно.



УДИРТГАЛ

Монгол Улс эрчим хүчний салбар түүхэн эргэлтийн цэг дээр ирээд байна. Нар, салхи болон сэргээгдэх эрчим хүчний бусад нөөцөөрөө дэлхийд тэргүүлэгч орнуудын нэгд тооцогддог Монгол Улс эрчим хүчний салбараа өөрчлөн шинэчлэх, үндэсний аюулгүй байдлаа хангах, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох боломжтой. Хэдийгээр асар их боломжит нөөц бололцоотой боловч өнөөгийн байдлаар сэргээгдэх эрчим хүч нь эрчим хүчний холимогт харьцангуй бага хувийг эзэлж байна. Монгол Улс нүүрс болон импортын цахилгаан эрчим хүчнээс хамааралтай хэвээр байна.

Энэхүү бодлогын баримт бичигт Монгол Улсын сэргээгдэх хүчний өнөөгийн нөхцөл байдал, хууль эрх зүй, бодлогын орчин, салбарын боломж, сорилт бэрхшээл, бүс нутгийн орнуудын жишээ сургамж, сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг хурдасгах бодлогын зөвлөмжийг оруулсан.

УДИРТГАЛ

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол орны өвөрмөц геологийн тогтоц нь сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх маш их боломжийг олгодог боловч [сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл эрчим хүчний ердөө 9 хувийг эзэлдэг](#). Манай улсын салхины эрчим хүчний нөөц гэхэд ойролцоогоор 1.1 тераватт цахилгаан бөгөөд жилд 2550 тераватт-цаг цахилгаан үйлдвэрлэх боломжтой гэсэн тооцоо бий.

[Азийн хөгжлийн банкны тооцоогоор](#), салхинаас гадна Монголын салхи, нарны хосолсон нөөц нь жилд 5457 ТВт.ц хүртэл цэвэр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх боломжтой бөгөөд энэ нь 2022 онд [Хятадын нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 63 хувьтай тэнцэх](#) юм. Энэ нөөц нь Монгол Улсыг Зүүн Хойд Азийн бүс нутагт цэвэр эрчим хүч экспортлогч болгоод зогсохгүй, 2030 он гэхэд экспорт нь дотоодын хэрэглээнээс давж гарах төлөвтэй байгаа БНХАУ-ын нарны эрчим хүч экспортлох боломжтой.


Өнөөдрийн байдлаар, Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадал [311 МВт](#) байгаа бөгөөд үүнээс нийтдээ 130 МВт хүчин чадалтай нарны 10 цахилгаан станц, нийтдээ 155 МВт хүчин чадалтай салхин 3 цахилгаан станц, нийтдээ 26 МВт хүчин чадалтай усан 6 цахилгаан станц нь сүлжээнд цахилгаан эрчим хүч нийлүүлдэг.

Сэргээгдэх эрчим хүч нь суурилагдсан хүчин чадлын 17.4 хувийг эзэлж байгаа нь дэд бүтэц, зохицуулалт, хөрөнгө оруулалтын сорилт бэрхшээл оршиж байгааг харуулж байна. Иймд устөрөгч, сэргээгдэх эрчим хүч, цэвэр эрчим хүч, сүлжээний шинэчлэл зэргийг Монгол Улсын бодлогын тэргүүлэх чиглэл болгох шаардлагатай.

Нарны цахилгаан станцуудаас үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг кВт.ц тутамд 483–588 төгрөг (≈ 14.2 – 17.3 ц), салхин цахилгаан станцаас гаргаж буй цахилгаан эрчим хүчийг кВт.ц тутамд 320–323 төгрөг (≈ 9.4 – 9.5 ц)-аар сүлжээнд худалдан борлуулдаг. Энэхүү мөрдөгдөж буй тариф нь дулаан, цахилгаан станцуудын үйлдвэрлэдэг цахилгаан эрчим хүчний дундаж тарифаас 4-6 дахин өндөр байна. Монгол Улсад засгийн газраас нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэдэг станцуудыг ихээхэн хэмжээний татаас дэмжсээр байгаа нь нүүрснээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг сэргээгдэх эрчим хүчнээс зохиомлоор хямд байлгадаг. 2024 оны төсвийн тодотголоор эрчим хүчний салбарыг дэмжих зорилгоор 131 тэрбум төгрөгийн татаас хуваарилдаг. Үүнийг өвлийн бэлтгэл хангах, нүүрсний нөөц бүрдүүлэх, импортоор цахилгаан эрчим хүч худалдан авах, тарифын алдагдлыг бууруулах, нийлүүлэгчийн төлбөр, татвар, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг өр төлбөрийг төлөх зэрэг арга хэмжээнд зарцуулдаг. Эдгээр арга хэмжээ цахилгаан станцуудыг санхүүгийн байдлыг тогтворжуулах, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг хангах зорилготой.


ЭРЧИМ ХҮЧ БА МОНГОЛ УЛСЫН БИЕ ДААСАН БАЙДАЛ:

ДОТООДЫН
ҮЙЛДВЭРЛЭЛЭЭР
ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХЭРЭГЦЭЭГЭЭ
ХАНГАХЫН ТӨЛӨӨХ
ЭРЭЛ ХАЙГУУЛ



Монгол Улсын эрчим хүчний дотоодын систем цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд чулуужсан түлшнээс ихээхэн хамааралтай бол нийт хэрэгцээгээ хангахад импортоор эрчим хүч худалдан авах шаардлагатай. Манай улсын нийт цахилгаан эрчим хүчний суурилуулсан хүчин чадал нь 1927 МВт гаруй бөгөөд уг хүчин чадлын дийлэнх нь чулуужсан түлшээр үйлдвэрлэгдэж, хүчин чадал, бодит үйлдвэрлэлд нүүрсээр ажилладаг дулаан, цахилгаан станцууд давамгайлдаг.

Дулааны нүүрсний цахилгаан станцууд суурилуулсан хүчин чадлын 82.1 хувийг эзэлдэг бол салхины (8.05%), нарны (8.05%), жижиг хэмжээний усан цахилгаан станц (1.4%) зэрэг сэргээгдэх эрчим хүч нь системийн хамаагүй бага хувийг эзэлдэг. Ерөнхийдөө сэргээгдэх эрчим хүч нь нийт суурилуулсан хүчин чадлын 18 орчим хувийг эзэлж, бодит цахилгаан үйлдвэрлэлийн 10 хүрэхгүй хувийг эзэлдэг.



82.1%

ДУЛААНЫ
НҮҮРСНИЙ
ЦАХИЛГААН
СТАНЦ



8.05%

САЛХИН
ЦАХИЛГААН
СТАНЦ



8.05%

НАРНЫ
ЦАХИЛГААН
СТАНЦ



1.4%

УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ

Үнэмлэхүй утгаар нь авч үзвэл, салхин цахилгаан станцууд 155 МВт орчим хүчин чадалтай бол нарны эрчим хүч нь салхитай адил хэмжээний хүчин чадалтай. Харин усан цахилгаан станц, дизель түлшээр ажилладаг цахилгаан үүсгүүрүүд нийт хүчин чадлын багахан хэсгийг эзэлдэг.

Монгол Улс хэрэгцээгээ дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлээр бүрэн хангаж чадахгүй байгаа учраас энэ дутагдлаа нөхөх зорилгоор ОХУ, БНХАУ-аас цахилгаан эрчим хүч импортлодог. 2024 онд дотоодын эх үүсвэрүүд нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний ¾-ийг хангасан бол импортын цахилгаан эрчим ¼-ийг хангасан.

Дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлийн ихэнхийг нүүрсээр ажилладаг дулаан, цахилгаан станцууд бүрдүүлдэг үлдсэн хэсгийг нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээр хангадаг.

Монгол Улсын Засгийн газар 2000 оноос хойш сэргээгдэх эрчим хүчний хэд, хэдэн санаачилгыг хэрэгжүүлж байна. Тухайлбал, малчин өрхүүдийг нарны эрчим хүчээр хангах замаар 100,000 нарны өрхийг цахилгаанжуулах хөтөлбөр (2000–2012)-ийг хэрэгжүүлсэн. [Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг](#) 2007 онд батлаж, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулж, ам.долларт суурилсан тарифыг мөрдөх болсон. Энэ хүрээнд, ойролцоогоор 137 МВт сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлыг хөгжүүлэх боломжтой болсон.

Монгол Улсын эрчим хүчний эрэлт өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа энэ үед хүчин чадлаа өргөжүүлэх, эх үүсвэрээ төрөлжүүлэх шаардлага үүссэн. Эрчим хүчний аюулгүй байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. 2010 онд батлагдсан [Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын](#) 3.2.4.2 дугаар хэсэгт "Эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад

эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана" гэсэн зорилт тавьсан.

Монгол Улс эрчим хүчний эх үүсвэрийг төрөлжүүлэхдээ сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарч байна. УИХ "[Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого](#)"-ыг 2015 оны 6 дугаар сард баталсан бөгөөд уг бодлогод, манай улсын нийт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувь хүртэл нэмэгдүүлэх стратегийн зорилтыг тодорхойлсон.

2024 онд Монгол Улсын дотоодын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл нь нийт цахилгаан эрчим хүчний хэрэгцээний 75.4 хувийг хангаж байсан бол үлдсэн 24.6 хувийг импортоор хангаж, голчлон ОХУ, БНХАУ-аас нийлүүлсэн. Дулааны цахилгаан станцууд нь дотоодын үйлдвэрлэлд давамгайлж, үйлдвэрлэлийн 90.6 хувийг эзэлдэг бол сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд 9.4 хувийг эзэлж байна. Сэргээгдэх цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд салхины эрчим хүч хамгийн их буюу 62.8 хувийг эзэлж, нарны эрчим хүч 28.2 хувийг, усан цахилгаан станц 9.0 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд импортын хамаарал дунджаар ¼ орчим боловч бүс нутгаас хамааран харилцан адилгүй байдаг. Монголын цахилгаан эрчим хүчний систем нь нэгдмэл, интеграцлагдсан биш, бүсийн эрчим хүчний бие даасан хэд, хэдэн системээс бүрддэг. Ховд, Увс, Баян-Өлгий аймгийг хангадаг [Баруун эрчим хүчний систем](#) нь ОХУ-ын эрчим хүчний системтэй хослон ажилладаг.

Эдгээр аймаг нь газарзүйн хувьд Төвийн эрчим хүчний системээс алслагдсан бөгөөд дотоодын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал маш хязгаарлагдмал. Ховд аймгийн Дөргөний усан цахилгаан станц нь 12 МВт орчим хүчин чадалтай бөгөөд орон нутгийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээний багахан хувийг хангадаг. Үүний улмаас баруун аймгууд цахилгаан эрчим хүчний

хэрэглээнийхээ 70 гаруй хувийг импортоор хангаж ирсэн бөгөөд усан цахилгаан станц нь бүс нутгийн нийт хэрэгцээний ердөө 25-30 орчим хувийг хангадаг.

Импортын нийт хамаарал 24.6 хувьтай байгаа нь импортоос хамааралтай бусад улстай харьцуулахад тийм ч өндөр биш мэт боловч Монгол Улс бүтцийн болон цаг уурын хүчин зүйлсээс өндөр хамааралтай. Ялангуяа ОХУ-аас импортлож буй цахилгаан эрчим хүч нь Баруун бүсийн эрчим хүчний сүлжээг бүрэн хангахаас гадна оргил ачааллын үед Төвийн бүсийн эрчим хүчний сүлжээг дэмжихэд зайлшгүй шаардлагатай байдаг. Монголын эрс тэс уур амьсгал болон Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн нийслэлүүдийн нэг зэргээс шалтгаалан өвлийн улиралд халаалт, цахилгаан эрчим хүчний эрэлтийг огцом нэмэгддэг учраас импортын цахилгаан эрчим хүч нь өвлийн улиралд онцгой шаардлагатай. Иймд эрчим хүчний хомсдолоос сэргийлэхэд хил дамнасан найдвартай эрчим хүчний хангамж зайлшгүй чухал.

62.8%

**САЛХИНЫ
ЭРЧИМ ХҮЧ**

28.2%

НАРНЫ ЭРЧИМ ХҮЧ

9.0%

**УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ**

**ОХУ,
БНХАУ-аас
импортлож
буй**

24.6%

75.4%

**Монгол Улсын
дотоодын
цахилгаан
эрчим хүчний
үйлдвэрлэл**

**ДУЛААНЫ
ЦАХИЛГААН
СТАНЦ**

90.6%

9.4%

**СЭРГЭЭГДЭХ
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ
ҮҮСВЭР**

Импортын эрчим хүчний хамаарал техникийн болон эдийн засгийн нөлөө үзүүлэхээс гадна Монгол Улсын стратегийн бие даасан байдал болон гадаад бодлогод шууд нөлөөлдөг. Хоёр хөршийнхөө эрчим хүчнээс хэт хамааралтай байгаа нь Монголын стратегийн уян хатан байдлыг хязгаарлаж, гадаад бодлогын бүрэн бие даасан шийдвэр гаргах чадварыг хязгаарладаг.

Эрчим хүчний эмзэг байдал нь Монгол Улсын гадаад бодлогод нөлөөлж, олон улсын маргаантай асуудлуудад болгоомжтой хандах шаардлагатай болдог. Эрчим хүчний хамаарлын улмаас Монгол Улс илэрхий бусадтай эвсэж

холбоолох юмуу эсвэл ил тод шүүмжлэх нь эрчим хүчний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Энэ утгаараа, Монгол Улс болгоомжтой, төвийг сахисан, заримдаа зориуд хоёрдмол байр суурь илэрхийлдэг. Эрчим хүчний хараат байдал нь Монгол Улсын олон улсын тавцанд илэрхийлэх байр суурийг гол тодорхойлогч хүчин зүйл болж байгаа бөгөөд эрчим хүчний аюулгүй байдал нь техникийн болон эдийн засгийн асуудал төдийгүй үндэсний бие даасан байдал, гадаад бодлогын бие даасан байдлын гол тулгуур болж байна.

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД АВСАН ҮҮРЭГ АМЛАЛТ БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Эрчим хүчний холимогт нүүрс давамгайлж байгаа хэдий ч Монгол Улсын Засгийн газар Алсын хараа-2050 болон Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд уур амьсгал, эрчим хүчний зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгож, 2030 он гэхэд суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30-д хүргэх зэрэг зорилтыг тодорхойлсон. Түүнчлэн, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенцийн Парисын хэлэлцээрийн хүрээнд, Монгол Улс хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд “ердийн үйл ажиллагаа”-ны түвшинтэй харьцуулахад 22.7 хувиар бууруулах үүрэг хүлээсэн бөгөөд энэ нь ойролцоогоор 16.89 сая тонн CO₂-тэй тэнцүү юм. Мөн үүнд 2030 он гэхэд эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн салбарт 8.34 сая тонн нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулах талаар тодорхой зорилт багтсан.

Олон улсын хэмжээнд авсан үүрэг амлалтынхаа хүрээнд, Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлд нийцсэн, нүүрстөрөгчийн багатай үйлдвэрлэлд шилжилтийг дэмжихэд чиглэсэн дунд болон урт хугацааны бодлого, зорилтуудыг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурал [Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг](#) баталж, нэмэлт, өөрчлөлт хэд, хэдэн удаа оруулсны дотор 2015, 2019 онд томоохон нэмэлт, өөрчлөлтүүд хийгдсэн. Хуулийн хүрээнд бий болсон эрх зүйн орчны хүрээнд, Монгол Улс тогтмол тарифаас өрсөлдөөнт худалдан авалтад шилжиж, зардал багатай эрчим хүчийг бий болгох боломжийг бүрдүүлсэн. Гэвч энэ тогтолцоог хараахан бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлагдсанаар, Эрчим хүчний зохицуулах хороо 2008-2018 оны хооронд 39 хуулийн этгээдэд нийт 1,352.4 МВт суурилагдсан хүчин чадал бүхий сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл олгоод байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу, төслийн хөгжүүлэгчид 7 дугаар зүйлд заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авах шаардлагатай. Дараа нь Эрчим хүчний зохицуулах хорооноос хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу, төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хугацаанд үндэслэн ам.доллараар илэрхийлэгдсэн тарифыг батална. 2019 онд батлагдсан нэмэлт өөрчлөлтөөр салхины эрчим хүчний тарифын дээд хязгаарыг 0.085 ам.доллар/кВт.ц, нарны фотоэлектрик төслүүдийн тарифын дээд хязгаарыг 0.12 ам.доллар/кВт.ц гэж тогтоосон. Нэмэлт өөрчлөлтүүд орохоос өмнө, тариф салхины эрчим хүчний хувьд 0.08-0.095 ам.доллар/кВт.ц, нарны фотоэлектрик эрчим хүчний хувьд 0.15-0.18 ам.долларын хооронд хэлбэлзэж байсан.

Тарифыг баталсны дараа, төслийн хөгжүүлэгчид Диспетчерийн үндэсний төвтэй (2019 оны нэмэлт өөрчлөлтөөс өмнө Цахилгаан дамжуулах сүлжээтэй) цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээ байгуулдаг. 11 дүгээр зүйлд мөн эцсийн хэрэглэгчдэд олгох сэргээгдэх эрчим хүчний дэмжлэгийн тарифыг тогтоосон. Нэг худалдан авагчийн загварт тулгуурлан, цахилгаан эрчим хүчний түгээх компаниуд энэхүү нэмэлт төлбөрийг цахилгааны төлбөртэй хамт цуглуулж, Диспетчерийн үндэсний төвийн удирддаг тэг үлдэгдэлтэй дансанд шилжүүлдэг. Уг дансыг сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдэд төлбөр хийхэд ашиглана.

2019 оны нэмэлт өөрчлөлтөөр сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд өрсөлдөөнт худалдан авалтын механизмыг (4 дүгээр зүйл) нэвтрүүлсэн боловч энэ системийг харахан хэрэгжүүлээгүй байна. Төслийн хэрэгжилтийн баталгааны шаардлагыг банкны баталгаа эсвэл бэлэн мөнгөний

хадгаламж хэлбэртэй байхаар тусгасан. Цахилгаан эрчим хүч худалдан авах бүх гэрээ нь 10 дугаар зүйлд заасны дагуу ийм баталгааг хангасан байх шаардлагатай.

Сэргээгдэх эрчим хүчний төслүүд нь татварын хөнгөлөлт эдэлдэг. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн (2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан) 13 дугаар зүйлийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвараас, мөн өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу импортын татвараас тус тус чөлөөлөгддөг.

Монгол Улсын Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх төслүүдэд өрсөлдөөнт дуудлага худалдаа зарлаж, тэдгээрийг Эрчим хүчний яамны тогтоосон техникийн шалгуур болон хөгжүүлэгчдийн санал болгосон өрсөлдөөнт үнийн саналд үндэслэн сонгохоор болсон. Энэ хүрээнд, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүчний системийн техникийн хүчин чадал болон ирээдүйд төлөвлөлт хийх тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан, 200МВт хүртэлх нарны болон 300МВт хүртэлх салхины эрчим хүчний хүчин чадлыг үе шаттайгаар өрсөлдөөнт байдлаар сонгохыг тусгасан.

2011 оноос хойш уул уурхайн салбарын цахилгаан эрчим хүчний тарифыг ААН-ийн хэрэглэгчдийн ерөнхий тарифаас тусад нь тогтоож, хэрэгжүүлж ирсэн. 2024 онд цахилгааны эрчим хүчний нийт хэрэглээнд, өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ ойролцоогоор 26 хувь, ААН-үүдийнх 43 хувь, уул уурхайнх 31 хувийг тус тус эзэлж байв.



ЭРЧИМ ХҮЧНИЙ РЕФОРМ

УИХ-ын 2024 оны сонгуулийн дараа, МАН, АН, ХҮН-ын нам, Иргэний зориг-Ногоон намын байгуулсан эвслийн засгийн газар эрчим хүчний салбарын цогц шинэчлэлийг хийж, хууль эрх зүйн хүрээ, тарифын бүтэц, институцийн зохион байгуулалтыг шийдвэрлэх үүрэг хүлээсэн. Зохицуулалтыг сайжруулах зорилгоор, Эрчим хүчний реформын үндэсний хороог 2024 онд байгуулсан боловч 2025 оны 6 дугаар сард эвслийн засгийн газар задарсны дараа татан буугдсан.

Төрийн өмчит компаниудыг нэгдсэн удирдлага, менежментээр хангах зорилгоор, Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн шийдвэрийн дагуу Үндэсний диспетчерийн төв, Улаанбаатарын дулааны сүлжээ, Дулааны цахилгаан станц II, III, IV, Үндэсний

цахилгаан дамжуулах сүлжээний компани зэрэг эрчим хүчний томоохон үйлдвэрлэгч, түгээгч байгууллага, сүлжээний оператор зэрэг уул уурхайн бус 44 төрийн өмчит аж ахуйн нэгжийг нэгтгэж, "Эрчист Монгол" ТӨХК ХХК-ийг байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар, "Эрчим Монгол" ТӨҮХК хүлээгдэж байсан үр дүнд хүрээгүй, санхүүгийн дарамт үүсгэж буй тул цаашид улам хүндрэхээс сэргийлж, татан буулгах нь зүйтэй гэж үзжээ.

2025 оны 7 дугаар сарын тогтоолоор найдвартай ажиллагааг хангах, зардлыг бууруулах, үйл ажиллагааны давхцлыг арилгах, үр ашгийг дээшлүүлэх бүтцийн шинэчлэлийг нэвтрүүлсэн. Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК болон Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийг Үндэсний цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-д нэгтгэж, есөн ТӨХК, найман салбарын үйл ажиллагааг нэгтгэн, 4 ААН болгосон. Энэхүү зохицуулалтыг бууруулж, сайжруулсан боловч институцийн хуваагдал, ялангуяа тариф тогтоох, зохицуулалтын тогтвортой байдал, төрийн өмчит компаниудын хариуцлагын асуудал саад тотгор болсон хэвээр байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН РЕФОРМ

2001 оны Эрчим хүчний тухай хуульд 15 гаруй нэмэлт өөрчлөлт орсон боловч бүтцийн шинэчлэл хийгдээгүй байна. УИХ-ын 80 дугаар тогтоолоор хууль эрх зүйн цогц шинэчлэлийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. 2025 оны 6 дугаар сард Засгийн газар төслийн сонголт, үнэ, эрчим хүчний хангамж, өмчлөлийг шилжүүлэх, мөн Төр хувийн хэвшлийн түншлэлийн болон Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг хуулийн төслийг өргөн барьсан. Гэвч хуулийн төслийг өргөн хүрээнд хэлэлцүүлэлтгүй баталж, хэрэгжүүлж эхэлсэн. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсврийг эрчим хүчний сүлжээнд холбогдсон бүтээн байгуулалтаар хязгаарлагдсан "эрчим хүчний шинэ төсөл" гэсэн ойлголтыг нэвтрүүлж, төсөлд хамаарах Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг зөвшөөрсөн нь хууль эрх зүйн зөрчилдөөн үүсч болзошгүй юм. Зөвшөөрлийн эрх мэдэл нь ЭХЯ-наас Эрчим хүчний яам руу шилжих бөгөөд сайдын удирдлаган дор төслийн сонголт, тариф, санхүүжилт, шилжүүлгийн нөхцөлийг хянадаг ажлын хэсэгтэй болно.

Монгол Улсын Эрчим хүчний сайд 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн А/217 дугаар тушаалаар сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх байгууламж барих төслийг сонгох шинэчилсэн журмыг баталж, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх төслүүдийг олон нийтэд зарлах, үнэлэх, сонгох, төсөл хөгжүүлэгчидтэй байгуулах гэрээний зохицуулалтыг тодорхойлсон. Өмнө үйлчилж байсан 2020 оны журамд 1 МВт-аас дээш хүчин чадалтай бүх төрлийн сэргээгдэх эх үүсвэрийг хамруулж байсан бол 2025 оны журамд зөвхөн 6 кВ ба түүнээс дээш хүчдэлд холбогдох нар, салхины төслүүдийг хамруулахаар хязгаарласан байна.

Журамд орсон гол өөрчлөлтүүдийг дурдвал, төсөл шалгаруулалтын урилгыг урьдчилсан үнэлгээ эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдэгдэх хугацааг 45-аас доошгүй буюу хугацааны хувьд илүү эрт нийтэд зарлахаар өөрчилсөн. Төсөл хэрэгжүүлэх баталгааг гаргах ба энэхүү баталгаа нь хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 1-5 хувьтай тэнцсэн байна. Төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг төрийн захиргааны байгууллагаас авна. Төслийн шалгаруулалтанд оролцогчид хууль эрх зүйн бүртгэл, санхүүгийн түүх, туршлага зэрэг стандартчилагдсан баримт бичгийг ирүүлэх ёстой бөгөөд төслийн техник, эдийн засгийн зардлыг тооцоолох тодорхой аргачлалыг нэвтрүүлсэн. Төслийн сонгон шалгаруулах үйл явцад урьдчилсан, техникийн болон санхүүгийн үнэлгээний үе шатууд, тодорхой онооны журам багтсан бөгөөд ялагчид мэдэгдэл хийснээс хойш ажлын 5 өдрийн дотор гэрээ байгуулах ёстой. Өмнөх журамд зааснаар хэрэв бусад оролцогчид шалгаруулалтын талаар маргаантай байгаа тохиолдолд гомдлыг шууд шүүхэд хүргүүлдэг байсан бол шинэчилсэн журмаар гомдлыг мэдэгдэл хүлээн авснаас 5 хоногийн дотор захиалагчид хүргүүлэх буюу шүүхэд хандахаас өмнө урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар нэмсэн байна.

ТАРИФЫН РЕФОРМ

2024 онд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн зардал дунджаар кВт. цаг тутамд 285 төгрөг байсан бол эцсийн хэрэглэгчийн тариф 216 төгрөг байсан нь 1.8 их наяд төгрөгийн хуримтлагдсан өрийг бий болгосон.

Эрчим хүчний зохицуулах хороо нь өрхийн гурван шатлалт тарифыг хэрэгжүүлж, цахилгаан эрчим хүчний дундаж зардлыг кВт.цаг тутамд 280 төгрөг болгон нэмэгдүүлсэн.



УЛС ТӨР ҮНИЙГ ТОГТООХ ҮЕД

Монгол Улсын эрчим хүчний зах зээл нь төвлөрсөн нэг худалдан авагчийн загвараар үйл ажиллагаа явуулдаг. Энэ загварын дагуу, цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэгчдээс худалдаж аваад түгээгч байгууллагуудад борлуулдаг. Энэхүү тогтолцоо нь цахилгаан эрчим хүчний өрсөлдөөнт үнэ, зээлийн зарчмаар ажиллах боломжийг хязгаарлаж, төр үнэ тогтоох болон үнийн ерөнхий бодлогод голлох үүрэгтэй оролцдог.

Эрчим хүчний үнэ нь хэрэглээний бараа, үйлчилгээний өртөгт шууд нөлөөлдөг учраас улс төрийн маш эмзэг асуудал юм.

Үүний улмаас улс төрчид олон нийтийн эсэргүүцлийг өдөөхөөс болгоомжилж, үнийг өсгөх сонирхолгүй байдаг. Үнийг өөрчлөх нь улс төрийн хязгаарлалттай байдаг тул тарифыг удаан хугацаанд зардлыг нөхөх түвшингээс доогуур байлгаж, төрийн болон төрийн өмчит компаниуд давамгайлсан эрчим хүчний салбар алдагдалтай ажилласаар ирсэн. Эрчим хүч үйлдвэрлэгчид тарифыг үйл ажиллагааны өртөг, зардлын өсөлтийг тусгасан байдлаар өөрчлөх шаардлага болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үнэ тариф нь хэвийн үйл ажиллагааг хангахад хүрэлцээтэй бус байгааг сануулдаг.

[Эрчим хүчний тухай хуулийн 26.2 дугаар зүйлийн](#) дагуу, Монгол Улс цахилгаан болон дулааны эрчим хүчний үнийг үйлдвэрлэлийн зардалд үндэслэн тогтоох "өртөг нэмэх" аргачлалыг баримталдаг. Эрчим хүчний зохицуулах хороо энэ аргачлалд хэд, хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. 2014 онд макро эдийн засгийн өргөн хүрээтэй хүчин зүйлүүдийг харгалзаж, "Эрчим хүчний үнэ, тарифыг индексжүүлэх журам"-ыг батлаж, индексжүүлэлсэн үнийг нэвтрүүлсэн. Өнөөдрийн мөрдөж буй "Цахилгаан болон дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлал"-ыг Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 504 тоот тогтоолоор баталж, 2014-2017 оны хооронд мөрдөгдөж байсан журмыг орлуулан хэрэгжүүлэхээр болсон. 2002-2024 оны хооронд тариф тогтоох аргачлалд өөрчлөлт хийсэн ба цахилгаан болон дулааны эрчим хүчний тарифт 12 удаа өөрчлөлт оруулжээ.

Өөрчлөлтүүд хийгдсээр байгаа боловч [эрчим хүчний бодит өртөг болон эцсийн хэрэглэгчийн төлдөг тарифын хооронд мэдэгдэхүйц зөрүү байсаар байна](#). Цахилгаан эрчим хүчний бодит өртөг нь киловатт-цаг тутамд ойролцоогоор 280 төгрөг байдаг бол 2024 оны сүүлээр тарифын өөрчлөлт хийхээс өмнө айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад ногдуулдаг дундаж тариф 216 төгрөг байв. Айл өрхийн тариф нь харьцангуй доогуур бөгөөд киловатт-цаг тутамд дунджаар 140 төгрөг буюу бодит өртгийн бараг тал

хувь нь байв. Үүнтэй төстэй тэнцвэргүй байдал халаалтын үнэ тарифт харагддаг ба дулааны эрчим хүчний өртөг нь гигакалори тутамд 63,000 төгрөг орчим байдаг хэдий ч Улаанбаатар хотын хэрэглэгчдэд дунджаар 33,800 төгрөгөөр борлуулдаг. Орон сууцны халаалтын тарифыг нэг ам метр тутамд 506 төгрөгөөр тогтоосон бол аймгийн төвүүдэд 800-1,024 төгрөг байдаг.

Тариф өртөг зардлаа нөхөх түвшингээс хамаагүй доогуур байгаагаас 2024 оны байдлаар нүүрсний уурхай, нүүрс тээвэрлэлт, эрчим хүчний салбар жилд 355 тэрбум орчим төгрөгийн алдагдал хүлээсэн. Богино хугацаат, хуримтлагдсан өр 357 тэрбум төгрөгт хүрч, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг ноцтойгоор алдагдуулж, үйлдвэрлэл, засвар үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг тасалдуулж байна. Бүтцийн болон санхүүгийн ийм сул талууд байгаа нь үйл ажиллагааны ачаалалд шууд нөлөөлдөг. Өвлийн оргил ачааллын үед, эрчим хүчний систем нь зохих тооны нөөц тоног төхөөрөмж байхгүй, үйл ажиллагааны өндөр эрсдэлтэй, онцгой байдлын горимд бүрэн хүчин чадлаараа ажилладаг.

Эрчим хүчний реформоос хүлээх хүлээлт өндөр байгаа хэдий ч Монгол Улсад цахилгаан тасалдал байнга гарсаар байгаа нь бизнес эрхлэгчид болон айл өрхүүдэд ихээхэн хүндрэл учруулж байна. Диспетчерийн үндэсний төв Улаанбаатар хотод бүрэн цахилгаан тасрахаас сэргийлж, цахилгаан эрчим хүчний хязгаарлалт 2026 оны 1 дүгээр сард хийх шаардлагатай болсон нь олон нийтийн бухимдлыг төрүүлсэн. Иргэд, бизнес эрхлэгчид эрчим хүчний үнийг нэмсэн нь эрчим хүчний найдвартай байдлыг сайжруулаагүйд бухимдалтай байна. Энэ байдал нь эрчим хүчний реформын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил болон бодит үр дүн хоорондоо зөрүүтэй байгааг харуулсан. Том оврын цахилгаан станцуудыг барьж, ашиглалтад оруулахгүй бол энэ салбар өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангаж чадахгүй байсаар байх бөгөөд эрчим хүчний хангамжид хязгаарлалт үүсэх нөхцөл болж байна.

Ийм нөхцөлд эрчим хүчний таатай тариф баримтлах нь цорын ганц тодорхойлогч хүчин зүйл биш байж болох боловч хувийн хөрөнгө оруулалт, ялангуяа сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг татахад шийдвэрлэх хүчин зүйл болсон хэвээр байна. Сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг тусгай лицензийн дэглэм болон харьцангуй өндөр тарифаар дэмжиж байгаа боловч эдгээр арга хэмжээ нь зах зээлд нийлүүлэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхгүй байна. Үйлдвэрлэлийн бодит өртгөөс хамаагүй доогуур байлгах замаар тогтоож байгаа эрчим хүчний үнэ нь зах зээлийн зарчмыг гажуудуулж, салбарын эдийн засгийн суурийг сулруулж, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн шинэчлэл хийх, хүчин чадал нэмэгдүүлэхэд санхүүжилт гаргах сонирхолгүй болгож байна.

Тогтоосон тариф өртгийг нөхөх түвшинд хүрэхгүй байгаа учраас эрчим хүчний

үйлдвэрлэгчид алдагдалтай, татаасаас хамааралтай ажиллаж, цахилгаан станцуудад техникийн шинэчлэл хийх, үйлдвэрлэх хүчин чадлаа өргөжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх урсгалыг багасгаж байна. Үүний улмаас дотоодын үйлдвэрлэл нь өсөн нэмэгдэж буй хэрэглээгээ гүйцэхгүй байх, Монгол Улс ОХУ, БНХАУ-аас өндөр өртөгтэй цахилгаан эрчим хүч импортлохоос өөр аргагүй байдалд орж, улсын төсөвт хүндрэл учруулж, алсдаа Монгол Улсын эрчим хүчний хувьд бие даасан байдлыг алдагдуулж байна.

Үнэ тарифыг зориудаар хямд тогтоох, хөрөнгө оруулалтыг хязгаарлах, импортын хараат байдлыг үүсгэх нь бүтцийн шинжтэй томоохон сорилт бэрхшээлийг үүсгэсэн. Иймд үнэ тарифт бодит зардлыг илүүтэй тусгах, зах зээлд тодорхой дохио болохуйцаар үнэ тогтоохгүй бол эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт татах, дэд бүтцийг шинэчлэх, эрчим хүчний хангамжийн найдвар байдлыг хангахад хүндрэлтэй байх төлөвтэй байна.

САЛБАРЫН БОЛОМЖ

Монгол Улс дотоодын санаачилга, олон улсын хамтын ажиллагааг хослуулах замаар сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг хурдасгах, эрчим хүчний бүтцээ төрөлжүүлэх, сүлжээний найдвартай байдлыг хангах, нүүрстөрөгч бага ялгаруулах эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилго тавьсан. 2025 оны сүүлээр Монгол Улсын Их Хурал 2035 он гэхэд гэр хорооллын 100,000 өрхийг нарны хавтан, цахилгаан халаалт, батерей хуримтлуураар хангах зорилготой "100,000 нарны гэр" санаачилгыг зарлаж, улс орон даяар ногоон эрчим хүчинд шилжих шилжилтийг дэмжиж байна. Энэ хөтөлбөр нь сүлжээний холбогдох явдлыг хялбарчилж, өрхүүд илүүдэл цахилгааны төлбөрийг улирал тутамдаа авах, нүүрстөрөгчийн зах зээлд оролцох боломжийг олгох, эрчим хүчний хүртээмж болон тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжсэн. Тэргүүн шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр АНУ-ын сэргээгдэх эрчим хүчний компаниудтай хөрөнгө оруулалт, эрчим хүчний реформ, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны боломжуудын талаар хэлэлцэх зорилгоор 2026 оны 1 дүгээр сард уулзсан.

Журамд өөрчлөлт орохоос өмнө, сэргээгдэх эрчим хүчний төслийн хөгжүүлэгчид өөрсдийн үнэлгээнд үндэслэн, сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бие даан төлөвлөж,

хөгжүүлдэг байсан. Харин одоо төрөөс эрчим хүчний мастер төлөвлөгөө, стратегийн баримт бичигт тулгуурлан, улс орны эрчим хүчний хэрэгцээ, бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн, тодорхой шинэ төслүүдийг хувийн хөгжүүлэгчдэд хуваарилахаар шийдсэн. Эдгээр төслийг олгохдоо өрсөлдөөнт худалдан авалтад тулгуурлаж, хувийн хөгжүүлэгчид тодорхой төслийн техникийн үзүүлэлт зэрэг үнэ болон бусад шалгуурт үндэслэн үнийн саналыг харгалзана. Өрсөлдөөнт худалдан авалтын хүрээг хараахан эцэслээгүй байгаа тул Засгийн Газар [Олон улсын санхүүгийн корпораци \(ОУСК\)](#), Азийн хөгжлийн банк (АХБ) зэрэг олон улсын байгууллагаас техникийн туслалцаа авч байна.

Эрчим хүчний яам, ОУСК хооронд байгуулсан "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хүрээнд ОУСК, түүний зөвлөх баг нь Монгол Улсад 100 МВт-ын хүчин чадалтай салхин цахилгаан станц барихад шаардлагатай олон улсын жишигт нийцсэн судалгаа болон баримт бичгүүдийг бэлтгэн, дэмжлэг үзүүлнэ. Мөн төслийн хүрээнд техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчин, нийгмийн нарийвчилсан судалгаа, тендерийн бичиг баримтыг бэлтгэх, тендерийг үйл явцыг зохион байгуулж, шалгаруулах, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг ажлууд хийгдэнэ.



Монгол Улс болон [ЕСБХБ](#) нь 2028 он гэхэд эрчим хүчний хадгалах, дамжуулах дэд бүтэцтэй 300 МВт хүртэлх нарны болон 200 МВт хүртэлх салхин эрчим хүчний хүчин чадлыг ашиглахад өрсөлдөөнт худалдан авалтыг дэмжих, техникийн туслалцаа, стратегийн төлөвлөлт ашиглан сүлжээний найдвартай байдлыг сайжруулах, чулуужсан түлшний хамаарлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Үүний зэрэгцээ [АХБ](#) нь Баруун болон Зүүн бүсийн эрчим хүчний системд холбох, 115 мегаваттын хүчин чадалтай нарны цахилгаан станц барьж, 65 мегаватт/237 мегаватт цагийн хүчин чадалтай цэнэг хураагуурын систем суурилуулах зорилготой "Нарны эрчим хүчийг тогтвортой ашиглах" санаачилгын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Энэ төсөл нь Монгол Улсад хийгдэх томоохон сэргээгдэх эрчим хүчний худалдан авалтуудын нэг бөгөөд анхны нарны болон цэнэг хураагуурын дуудлага худалдаа болох юм. Төсөл нь цахилгаан дамжуулах сүлжээний найдвартай байдлыг нэмэгдүүлэх, нүүрсний хэрэглээг бууруулж, импортоор авах цахилгааны хамаарлыг багасгах, алслагдсан бүс нутагт цэвэр,

боломжийн үнэтэй эрчим хүч хүргэх зорилготой.

Төрөөс дангаараа болон олон улсын хамтын ажиллагаагаар хэрэгжүүлж буй эдгээр төсөл хөтөлбөр нь Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, цэвэр эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг тэлэх, тогтвортой эдийн засгийг өсгөхөд чиглэж байна.

Нар, салхины асар их нөөц бололцоотой Монгол Улс гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг улам бүр татаж байгаа боловч эрчим хүчний тарифын загвар, түвшин, түүний дотор нэмэлт тариф болон бусад үнийн механизм нь хөрөнгө оруулалтын тогтвортой байдалд чухал үүрэгтэй байсаар байна. Эхний үед мөрдөж байсан тариф нь гадаадын хөрөнгийг татахад дэмжлэг үзүүлдэг боловч илүү өрсөлдөхүйц, урьдчилан таамаглах боломжтой үнийн бүтэц нь Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтын сонирхлыг улам бүр нэмэгдүүлж, урт хугацааны ашигт ажиллагаа, тогтвортой байдлыг хангах боломжтой гэдгийг хөгжүүлэгчид онцолж байна.

САЛХИТЫН САЛХИН ЦАХИЛГААН СТАНЦ:

МОНГОЛЫН АНХНЫ ХУВИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ



2004 онд байгуулагдсан Клин Энержи ХХК нь Монголын анхны хувийн хөрөнгө оруулалттай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох Салхит салхин цахилгаан станц (ССЦС)-ыг барьж, ашиглалтанд оруулсан. Монголын эрчим хүчний систем нүүрснээс ихээхэн хамааралтай байсан үед тус компани томоохон хэмжээний сэргээгдэх эрчим хүчний төслүүд хувийн хөрөнгө оруулалт татах болон олон улсын хамтын ажиллагаа бий болгох замаар амжилтанд хүрч болохыг харуулсан.

Салхитын салхин цахилгаан станц Монгол Улсад анхдагчид тооцогдох хэд, хэдэн ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус цахилгаан станц нь төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон анхны салхин цахилгаан станц юм. Мөн сэргээгдэх эрчим хүчний салбарт анх удаа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан цахилгаан станц ба НҮБ-д бүртгэгдсэн хамгийн том Цэвэр хөгжлийн механизмын төсөл болсон.

Төслийн нийт өртөг нь 170 тэрбум орчим төгрөг бөгөөд хөрөнгө оруулагчид нь Ньюком групп, Женерал Электрик компани, Европын сэргээн босголт хөгжлийн банк болон Нидерландын санхүүгийн хөгжлийн агентлаг юм.

Техник технологийн хувьд станц нь 50МВт-ын хүчин чадалтай, Женерал Электрик компанийн 1.6-82.5хле загварын 31 салхин цахилгаан үүсгүүртэй, 27км урт 35кВ-ын кабелийн сүлжээг ашигладаг. Мөн анх удаа дэвшилтэт технологи болох 110кВ-ын Хийн тусгаарлалттай хуваарилах байгууламж (GIS)-ийг ашиглаж, Тристорын удирдлагатай Статик Вар Компенсатор (SVC)-ийг суурилуулсан. Салхин цахилгаан үүсгүүрүүдийг алсаас удирдах Wind-SCADA систем болон дэд станцын тоноглолыг удирдах Substation-SCADA системийг ашиглаж байна.

Салхин цахилгаан станц нь 50 МВт хүчин чадалтай бөгөөд Женерал Электрик компанийн 31 ширхэг 1.6-82.5 турбинаар ажилладаг. Үүнд 27 км урттай 35 кВ-ын кабелийн сүлжээ, термоблок барилгад байрлах улсын анхны 110 кВ-ын хийн дулаалгатай дэд станц, сүлжээний тогтвортой байдлыг хангах тиристороор удирддаг статик VAR компенсатор, алсын зайнаас хянах SCADA систем зэрэг дэвшилтэт дэд бүтцийг нэвтрүүлсэн. Барилга угсралтын ажил 2011 онд бэлтгэл ажлаас эхлэж 2013 оны 6 сард станц ашиглалтанд орж, тасралтгүй

үйл ажиллагаа явуулж байна. Барилга угсралтын ажилд нийт 4000 гаруй ажилчид оролцсны 95 хувь нь монголчууд байв.

2024 оны байдлаар Төвийн бүсийн эрчим хүчний хэрэглээний 3 хувийг хангаж, ойролцоогоор 80,000 гаруй айл өрхийн жилийн цахилгааны хэрэглээг хангаж байна. Мөн жилд 122 мянган тонн түүхий нүүрс хэмнэж, 1.6 сая тонн цэвэр усны хэрэглээг бууруулж, хүлэмжийн хийн ялгарлыг жилд 180 мянган тонноор

бууруулж байна. Клин Энержи ХХК болон Салхит салхин цахилгаан станцын амжилт нь хувийн хөрөнгө оруулалт, орчин үеийн технологи, олон улсын түншлэл нь Монголд тогтвортой хөгжлийг хэрхэн бий болгож болохыг харуулсан.

Энэхүү төсөл нь Монголын эрчим хүчний шилжилтийн чухал үе шат бөгөөд ирээдүйд хэрэгжих сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн загвар болж байна.



СОРИЛТ БЭРХШЭЭЛ

Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний хөгжилд хөрөнгө оруулагчдын итгэлийг алдагдуулж, салбарын ахиц дэвшлийг удаашруулдаг бүтэц, институц, засаглалын сорилт бэрхшээлүүд хязгаарлалт болж байна. Мөн [эрчим хүчний хуучирсан дэд бүтэц](#) нь өсөлтийг хязгаарладаг. Монголын цахилгаан эрчим хүчний системийн ихэнх хэсэг нь 1960-1980-аад оны үед баригдсан ба ялангуяа, Төвийн эрчим хүчний системд нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцууд давамгайлдаг. Эдгээр хуучирсан байгууламж нь 15-25 хувийн алдагдалтай, нөөцийн тухайд хязгаарлагдмал. Баруун,

Төв, Зүүн болон Алтай-Улиастайн сүлжээний хооронд сул холболт байдгаас үүдэн хүндрэлтэй тулгарч байна. Монгол Улсын Эрчим хүчний мастер төлөвлөгөө болон Азийн хөгжлийн банкны үнэлгээнд удаа дараа онцлон дурдаж байсанчлан, сүлжээний интеграцлал хангалтгүй, шинэчлэл хойшлогдож байгаа нь салхи, нарны эрчим хүч зэрэг сэргээгдэх эрчим хүчний хувьсах эх үүсвэрийг шингээх, тэнцвэржүүлэх чадварыг хязгаарлаж байна.

Биет дэд бүтэцтэй холбоотой сорилт бэрхшээлээс гадна, сэргээгдэх эрчим хүчний салбарт төрийн хэт их оролцоо нь институцийн томоохон сорилт болж байна. Төрийн байгууллага, хувь албан тушаалтнуудын шийдвэрээс хэт хамааралтай байх нь зохицуулалтын оролцоог тогтворгүй болж, төслийн үр дүнг урьдчилан таамаглах боломжгүй болгодог. Төрийн байгууллагуудад хувийн хэвшилд ашигладаг бизнесийн удирдлага, арилжааны эрсдэлийн үнэлгээ, зах зээлд суурилсан үйл ажиллагааны чиглэлээр ажилласан туршлагатай хүний нөөц дутмаг байдаг. Үүнээс болоод үнэ тогтоох, худалдан авах, төсөл батлах, хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа шийдвэрийг гаргахад ил тод, дүрэм журам, зах зээлийн зарчимд суурилах гэхээсээ илүүтэй захиргааны болон улс төрийн үүднээс ханддаг. Ийм орчин бүрэлдсэн байгаа нь инновацийг бий болгох, бизнес эрхлэгчид санаачилга гаргах боломжийг хязгаарлаж, урт хугацааны төслүүдийг төлөвлөж ажилладаг хөрөнгө оруулагчдад тулгардаг тодорхойгүй байдлыг нэмэгдүүлдэг.

Засаглалтай холбоотой үүссэн сул тал нь төрийн байгууллагууд өмнө нь тохиролцож байгуулсан гэрээгээ хэрэгжүүлэхгүй, хүлээсэн үүргээ тууштай биелүүлж чадахгүй байгаагаас үүдэлтэй. Төрийн байгууллагууд гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлж, биелүүлэхгүй байх үед хууль эрх зүйн тодорхой байдал алдагдаж, зохицуулалтын урьдчилан таамаглах боломжгүй байдал үүсдэг. Гэрээний үүрэг биелүүлнэ гэдэг нь итгэх итгэл алдагдах нь дотоодын болон олон улсын хөрөнгө

оруулагчдын итгэлийг бууруулж, хөрөнгө оруулах сонирхолгүй болоход нөлөөлдөг. Энэ байдал тогтвортой бодлого, урт хугацааны хөрөнгө оруулалт шаарддаг сэргээгдэх эрчим хүчний салбарт сөргөөр нөлөөлнө.

Өмнө нь байгуулсан гэрээг биелүүлээгүйн улмаас үүссэн үр дагавар нь тухайн гэрээний цар хүрээнээс давж гарахуйц нөлөөг бий болгодог. Байгуулсан гэрээгээ мөрддөггүй гэсэн мессеж өгөх нь хөрөнгө оруулалтын хүрээнд тархаж, сэргээгдэх эрчим хүчний төслүүд хэрэгжүүлэхийг зорьж буй Монгол Улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй сөрөг жишиг бий болгодог. Боломжит түншүүд, төслийн хөгжүүлэгчид гэрээний үүргээ зөрчдөг байдлыг зохицуулалтын хүрээний эрсдэлийн дохио хэмээн үзэж, урьдчилан таамаглах боломжтой улс орнуудад хөрөнгө оруулалт хийхэд хүргэж болзошгүй юм. Энэ байдал нь эргээд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хурдыг удаашруулж, технологи дамжуулах явдлыг хязгаарладаг. Үүнээс шалтгаалаад, Монгол Улс салхи, нар, цэвэр эрчим хүчний бусад нөөцөөр арвин боловч эрчим хүчний холимогоо төрөлжүүлэх боломжийг хязгаарладаг.

Институцийн болон гэрээний биелэлттэй холбоотой сорилтуудыг шийдвэрлэх нь хөрөнгө оруулалт татаад зогсохгүй Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний болон эдийн засгийн өргөн хүрээтэй зорилтуудыг хэрэгжүүлж чадах эсэхэд чухал юм. Гэрээгээ хэрэгжүүлэх, маргаан шийдвэрлэх механизмыг сайжруулах, тууштай, ил тод байдлыг бий болгох нь Монгол Улс тогтвортой эрчим хүчний хөгжлийг дэмжихэд нухацтай хандаж байгааг хөрөнгө оруулагчдад харуулна. Энэ алхамыг хийхгүйгээр хөрөнгө оруулагчид Монгол Улсад хөрөнгө оруулахдаа болгоомжтой хандсан хэвээр байх, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглах боломжгүй болно.


Төрөөс эрчим хүчний салбарт хатуу хяналт тавьж байгаа нь сэргээгдэх эрчим

хүчний хөгжлийг өрсөлдөөнт зах зээлийн хүчин зүйл гэхээсээ илүү улс төрийн зорилтуудаас хамааралтай болгож байна. Үүнээс үүдэн, үнэ тогтоох, худалдан авах, төсөл батлах, гэрээний хэрэгжилттэй холбоотой гаргадаг шийдвэрүүд нь хувийн хөрөнгө, мэргэжлийн ур чадварыг татахад чиглэсэн, ил тод, дүрэм журамд суурилсан үйл явцаас илүүтэй захиргааны ажилтнуудын үзэмжээс хамааралтай болгох талтай. Энэ байдал хөрөнгө оруулалтын урт хугацааны төлөвлөлт хийх боломжийг тодорхойгүй болгож, Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхээр бодолцож буй дотоодын болон гадаадын хөгжүүлэгчдэд эрсдэлийн дохио болж очих магадлалтай.

Төрийн шууд оролцоог бууруулж, хувийн хэвшлийг урьдчилан таамаглах боломжтой зах зээлийн орчинд, илүү чөлөөтэй ажиллах боломжийг олгосноор

сэргээгдэх эрчим хүчний салбар үр ашиг, өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой. Хувийн хөгжүүлэгчид тодорхой зохицуулалт, ил тод тарифын механизмтай, гэрээний хэрэгжилтийн найдвартай байдлыг бий болгосон орчинд, өрсөлдөөнт зах зээлд ажиллах нь инновацийг дэмжиж, хөрөнгийн олон төрлийн эх үүсвэрийг татаж, хувийн компаниудын бизнесийн ноу-хау, технологийн туршлагыг ашиглах боломжийг бүрдүүлнэ. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон хөгжлийн түншүүд нь Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний зах зээлд хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх санаачилгыг дэмжсээр ирсэн. Тухайлбал, салхины эрчим хүчний төслүүдэд хувийн хөрөнгө, туршлагыг ашиглахад чиглэсэн өрсөлдөөнт худалдан авалтыг зохион байгуулах төр, хувийн хэвшлийн түншлэлийн загварууд зэргийг дэмжсээр ирсэн.

ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ: КАЗАХСТАН УЛСЫН ТУРШЛАГА



Казахстан, Узбекистан зэрэг улсын туршлагаас өрсөлдөөнт худалдан авалт зохион байгуулах, сүлжээний бэлтгэл ажлыг хангах замаар сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг хэрхэн хурдасгадгийг харж болно. Сүүлийн 10 жилд Казахстан, Узбекистан эрчим хүчний үндэсний стратегиа өөрчилж, сэргээгдэх [эрчим хүчийг хөгжүүлэхийг тэргүүлэх чиглэл болгосон](#). Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан эдгээр орон нь Монгол Улстай олон

талаараа адил төстэй. Эдгээр гурван улс Евразийн бүс нутагт байрладаг, коммунист тогтолцооны үед баригдсан эрчим хүчний дэд бүтэцтэй, чулуужсан түлшнээс хэт хамааралтайгаар төстэй. Гурван улс нүүрстөрөгчийн түлшнээс цэвэр эрчим хүч рүү шилжих шилжилтийг хурдасгах зорилгоор нар, салхины эрчим хүчний төслүүдийг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч байна.

[Казахстан](#) улсын ногоон эрчим хүчинд шилжсэн шилжилтийн онцлогийг авч үзвэл, тус улс төслүүдийг сонгоход ашигладаг өрсөлдөөнт худалдан авалт, хөрөнгө оруулагчдын санхүүгийн чадавхи, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан нарны болон салхины цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэлбэлзлийг харгалзан сүлжээний уян хатан байдлыг хангасан. Казахстан улсын засгийн газар хамгийн бага үнийн санал өгсөн байгууллагад цэвэр эрчим хүчний гэрээг олгодог бөгөөд ингэснээр салбарын өрсөлдөөнт худалдан авалтыг стандартчилж, өрсөлдөөний үр дүнд үнийг бууруулах боломжтой болсон. Мөн тодорхой бөгөөд найдвартай орлогыг нотолж харуулсан тохиолдолд хэрэгжүүлж буй төслүүдийн боломжит [хөрөнгө оруулагчид банкуудаас зээл авах бололцоо хялбар болгосон](#). Нөгөөтэйгүүр, Монгол Улс өрсөлдөөнт худалдан авалт руу шилжих үйл явцыг эхлүүлсэн боловч сэргээгдэх эрчим хүчний төсөл байгуулагдсны дараа тогтмол тариф төлөхөөс хамааралтай хэвээр байна. Энэ байдал гэрээт гүйцэтгэгчдийн санхүү сул, тариф хэт бага, байгуулсан гэрээ нь салбарын хэмжээнд стандартчилагдаагүй тохиолдолд, төслийн үйл явцыг урьдчилан таамаглах аргагүй, санхүүгийн хувьд тогтворгүй болгох үр дагаварт хүргэдэг.

Казахстаны цахилгаан үйлдвэрлэх дэд бүтэц нь жилийн тодорхой үед салхи, нарны хомсдолоос үүдэлтэй хэлбэлзлийг шингээж авснаар, сэргээгдэх эрчим хүчний

эх үүсвэрийн хурдацтай тэлэх боломжийг бүрдүүлж байна. [Сүүлийн 4 жилд](#) ногоон эх үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний үйлдвэрлэлийн эзлэх хувь 2 хувиас 7 хувь болж өссөн явдал нь үүнийг нотолж байна. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний сүлжээ дутагдалд орох нь олонтоо бөгөөд нар, салхийг хурдан шингээж авах байдал, чадавх дутмаг байна. Монгол Улс нүүрстөрөгчийн саармагжуулах урт хугацааны зорилгоо тогтвортой эрчим хүчний хэрэгцээтэй тэнцвэржүүлэх шаардлагатай болж байна.

Казахстан улсын туршлагаас үзэхэд, сэргээгдэх эрчим хүчийг цаг алдалгүй хөгжүүлэх нь худалдан авалтын хүртээмж, гэрээг тууштай биелүүлэх байдал, сэргээгдэх эх үүсвэрээс эрчим хүчний үйлдвэрлэлд дасан зохицох чадвартай цахилгаан сүлжээнээс хамаарч байна. Монгол Улсын хувьд асуудал гол нь сэргээгдэх эрчим хүчний нөөц биш, харин сүлжээний чадавхи, бэлэн байдал, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулах механизмд оршиж байна. Казахстаны хэрэгжүүлсэн загвар нь дуудлага худалдааны үйл явц болон ногоон төслүүдээс олох орлогыг урьдчилан таамаглах боломжтой байлгах замаар хувийн хөрөнгө оруулалтыг хэрхэн дэмжиж болохыг харуулж байна. Монгол Улс эрчим хүчний нийт хэрэгцээгээ хангахад нар, салхи зэрэг эрчим хүчний өөр эх үүсвэрийг эрэлхийлсэн тохиолдолд эдгээр давуу талыг бий болгох боломжтой.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний асар их нөөц нь эрчим хүчний салбартаа реформ хийх, эрчим хүчний бие даасан байдлыг бэхжүүлэх, дэлхийн хэмжээнд хүлээсэн уур амьсгалын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах онцгой боломжийг олгож байна. Гэвч энэ зорилтуудыг бодитой хэрэгжүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл болгоход бүтэц, институц, санхүүгийн саад бэрхшээлийг

шийдвэрлэх шаардлагатай. Сайтар бодож боловсруулсны үндсэн дээр хэрэгжүүлэх бодлогын реформ, олон улстай тогтоосон стратегийн хамтын ажиллагаа, зах зээлд чиглэсэн шийдэмгий үйлдэл хийх замаар Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний нөөц чадавхиа зөвхөн дотоодын өсөлтийг хангах хөдөлгүүр төдийгүй бүс нутгийн эрчим хүчний хэрэгцээг хангах чухал тулгуур болгох ирээдүйг бүтээх боломжтой.

БОДЛОГЫН СОНГОЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний боломжийг бүрэн нээх, хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтыг өргөн хүрээнд татах, салбарын тогтвортой өсөлтийг хангахын тулд цогц бодлого хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай байна. Монгол Улс өрсөлдөөнт худалдан авалт, сэргээгдэх эрчим хүчний шинэ

төслийн төлөвлөлт зэрэг томоохон зорилтыг тавьж, шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэн боловч цаашид ахиц дэвшлийг хурдасгахад тарифын загвар, хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалахтай холбоотой саад бэрхшээлийг шийдвэрлэх шаардлагатай байна.

1. БОДИТ ЗАРДАЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН ДИНАМИКИЙГ ТУСГАХ ЗОРИЛГООР ТАРИФЫН ТОГТОЛЦООГ ШИНЭЧЛЭХ, САЙЖРУУЛАХ

Эрчим хүчний үнийн тогтолцоог шинэчлэх нь шаардлага бий бөгөөд ингэснээр тариф нь сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл болон сүлжээний интеграцийг бий болгох бодит зардлыг илүү нарийвчлалтай тусгах, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах өгөөжийг бий болгох юм. Анх сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг татахдаа, Монгол Улс харьцангуй өндөр тариф санал болгодог байсан нь тухайн үедээ хөрөнгө оруулагчдын сонирхлыг бий болгосон боловч технологийн зардал буурч, өрсөлдөөний механизм улам бүр шаардлагатай болж байгаагаас шалтгаалан өндөр тариф санал болгох нь үеэ өнгөрөөж байна.

- Нар, салхины төслүүдийн урт хугацааны өртгийн бүтэцтэй байдаг илүү нягт уялдуулан тарифыг өөрчлөх шаардлагатай бөгөөд үүнд засвар үйлчилгээ, санхүүжилтийн зардал, эрсдэлийн шимтгэл орно.
- Үе шаттай тарифын баталгаа (жишээлбэл, 15-20 жилийн хугацаатай) болон инфляцитай холбоотой өөрчлөлт хийх нь хөгжүүлэгчдэд санхүүжилтийг баталгаажуулахад шаардлагатай орлогын тогтвортой байдлыг бий болгоно.
- Хөрөнгө оруулагчдын итгэл болон зах зээлийн өрсөлдөх чадварыг тэнцвэржүүлэхийн тулд нөөцийн аюулгүй байдлыг зах зээлийн үнэтэй хослуулсан тарифын холимог загваруудыг авч үзэх.

Төрийн үзэмжээр тогтоодог үнийн тогтолцооноос өртөг зардлыг бодитоор тусгасан үнэ рүү шилжсэнээр, Монгол Улс санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулж, урьдчилан таамаглах боломжтой өгөөжийг илүү сайн харуулж чадна.

2. ИЛ ТОД ДҮРМЭНД СУУРИЛСАН ӨРСӨЛДӨӨНТ ХУДАЛДАН АВАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ

Өрсөлдөөнт худалдан авалт нь олон улсад сэргээгдэх эрчим хүчний өртгийн хэмнэлт бүхий үнийг бий болгох, хувийн хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх хамгийн үр дүнтэй аргуудын нэг гэж хүлээн зөвшөөрөгдсөн. Монгол Улс салхи, нарны эрчим хүчний дуудлага худалдаанд суурилсан худалдан авалтын эхний алхмуудыг хийсэн бөгөөд үүнд ОУСК зэрэг байгууллагаас өрсөлдөөнт тендерийн хүрээг бэлтгэх техникийн туслалцаа үзүүлэх зэрэг орно.

- Дуудлага худалдааны мөчлөг бүрийн өмнө оролцох шалгуур, тендерийн үнэлгээний шалгуур, үнийн хязгаар, ил тод байдлын шаардлагыг тодорхойлж, тендерийн тодорхой дүрмийг боловсруулах, хэвлэж тараах.
- Тодорхой бус байдлыг бууруулж, төслийн хөгжүүлэгчдэд төлөвлөх боломжийг олгохын тулд дуудлага худалдаа явуулах хуваарийг тогтмол, урьдчилан таамаглах боломжтой мөрддөг байх.
- Гүйцэтгэх боломжгүй, гуравдагч талд дамлан худалдах эрсдэл бүхий тендерээс зайлсхийх зорилгоор гэрээг биелүүлээгүй тохиолдолд, ноогдуулах торгууль болон санхүүгийн чадавхитай холбоотой шаардлага оруулах.

Ил тод дуудлага худалдаа явуулах нь өрсөлдөөнт үнийн саналыг бий болгож, төслийн зардлыг бууруулж, олон улсын хөрөнгө оруулагчдын дунд системийн итгэлийг нэмэгдүүлэх юм.

3. ӨРСӨЛДӨӨНТ ХУДАЛДАН АВАЛТЫГ ДЭМЖИХИЙН ТУЛД ЗАХ ЗЭЭЛИЙГ ЛИБЕРАЛЧЛАХ

Монгол Улсад одоо хэрэгжиж буй Нэг худалдан авагчийн загвар нь төрийн байгууллагад эрчим хүчний худалдан авалтыг төвлөрүүлдэг нь үнээр өрсөлдөхийг хязгаарлаж, зах зээлд очих дохио мессежийг гажуудуулж болзошгүй юм. Зах зээлийг томоохон үйлдвэрлэлийн хэрэглэгчид зэрэг өргөн хүрээнд ажилладаг худалдан авагчдад нээлттэй болгосноор орлогын урсгалыг төрөлжүүлж, зах зээлийг хөгжлийг дэмжих боломжтой.

- Мэргэшсэн эцсийн хэрэглэгчид (жишээ нь, арилжааны болон үйлдвэрлэлийн салбарууд)

сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдтэй шууд эрчим хүчний худалдан авалтын гэрээ байгуулахыг зөвшөөрөх.

- Үнэ нь эрэлт болон нийлүүлэлтийн үндсэн зарчмуудыг тусгасан байх, өрсөлдөөнд суурилсан цахилгаан эрчим хүчний бөөний зах зээл рүү аажмаар шилжих.
- Уян хатан байдал, сүлжээний дэмжлэг, хадгалах байгууламжийн интеграцийг урамшуулдаг туслах үйлчилгээ, тэнцвэржүүлэгч зах зээлийг бий болгох

Зах зээлийг илүү өрсөлдөөнтэй болгох нь нэг худалдан авагчаас хамааралтай байдлыг бууруулж, сэргээгдэх эрчим хүчний хөгжүүлэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулах боломжийг нэмэгдүүлнэ.

4. СҮЛЖЭЭНИЙ ДЭД БҮТЭЦ БОЛОН ИНТЕГРАЦИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ

Үр дүнтэй тариф болон зах зээлийн шинэчлэл хийсэн ч гэсэн сүлжээний хувьсах сэргээгдэх эрчим хүч (VRE)-ийг шингээх чадвар маш чухал юм. Монгол Улсын одоо байгаа дамжуулах систем нь хуучин дэд бүтэцтэй бөгөөд салхи, нарны эрчим хүчийг өндөр хувиар, бүрэн оновчтой шингээх боломжгүй байгаа нь хязгаарлалт үүсгэж, найдвартай байдлыг хангахад сорилт учруулж байна.

- Сэргээгдэх эрчим хүчээр баялаг бүс нутгийг эрчим хүчний хэрэглээний ачааллын төвүүдтэй холбоход дамжуулах дэд бүтэцэд хөрөнгө оруулах.
- Хувьсах чанарыг жигдрүүлж, сүлжээний тогтвортой байдлыг хадгалахад туслах эрчим хүчийг хадгалах шийдлүүдийг (жишээлбэл, хэрэглээний батерей хуримтлуур) нэвтрүүлэхийг нэн тэргүүнд тавих.
- Уян хатан байдлыг нэмэгдүүлэх, интеграцийн зардлыг бууруулахын тулд сүлжээний дэвшилтэт менежментийн технологийг (жишээлбэл, ухаалаг сүлжээ, эрэлтэд үзүүлэх хариу арга хэмжээ) нэвтрүүлж хэрэгжүүлэх.

Эрчим хүчний дамжуулах сүлжээнд стратеги хөрөнгө оруулалт хийх нь сэргээгдэх эрчим хүчний нэмэлт хүчин чадлыг найдвартай үйл ажиллагаагаар хангахад тустай юм.

5. ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ УРЬДЧИЛАН ТААМАГЛАХ БАЙДАЛ БОЛОН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ

Хөрөнгө оруулагчид аливаа төсөлд хөрөнгө оруулахдаа зохицуулалтын орчин тодорхой байх, итгэлцэл бий болсон байхыг шаарддаг. Тогтворгүй дүрэм журам, урьдчилан таамаглах аргагүй тариф, гэрээний хэрэгжилт сул байх нь урт хугацааны хөрөнгө оруулалт орж ирэх боломжийг бууруулдаг.

- Монгол Улсын хууль эрх зүйн орчинд итгэх итгэлийг бий болгохын тулд одоо мөрдөгдөж буй эрчим хүч худалдан авах гэрээ болон сэргээгдэх эрчим хүчний төслийн гэрээний хэрэгжилтийг сайжруулах.
- Хөрөнгө оруулагч болон засгийн газар хоорондын маргааныг үр дүнтэй шийдвэрлэх бие даасан юмуу эсвэл эрчим хүчний мэргэшсэн арбитрын механизмыг бий болгох
- Улс төрийн үзэмжээр төсөлд ханддаг байдлыг хязгаарлах, зохицуулалтыг ил тод, хэмжигдэхүйц шалгуурт үндэслэсэн байлгах замаар тариф тогтоох үйл явцыг журамлах.

Зохицуулалтын орчны тодорхой байдлыг сайжруулснаар Монгол Улсыг өөр зах зээлтэй харьцуулж буй гадаадын хөгжүүлэгчдийн хувьд тооцоолох эрсдэлийг бууруулах юм.

6. АРИЛЖААНЫ ОЛОН ТӨРЛИЙН ЗАГВАР БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООГ УРАМШУУЛАХ

Шинэ төрлийн төсөл, санхүүжилтийн загваруудыг хэрэгжүүлэхэд Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний бизнесийн бүтцийг дэмжих шаардлагатай.

- Төр болон хөрөнгө оруулагчдын хооронд эрсдэл болон ашгийг тодорхой байдлаар хуваарилдаг төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих.
- Цахилгаан сүлжээнд холбох, нөхөн олговрын тодорхой дүрэм журмыг тусгасан, цахилгаан

эрчим хүчний тархмал үйлдвэрлэл болон орон нутгийн сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

- Төсөл хөгжүүлэгчдийн орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх зорилгоор эрчим хүчний худалдан авалтын виртуал гэрээ (VPPA) болон сэргээгдэх эрчим хүчний байгууллагын худалдан авалтыг идэвхжүүлэх.

Эдгээр арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын бааз суурийг өргөжүүлж, сэргээгдэх эрчим хүчний байршуулалтыг хурдасгах боломжтой санхүүжилтийн шинэлэг механизмыг нэвтрүүлнэ.

7. ОЛОН УЛСЫН ТҮНШЛЭЛ БОЛОН УУР АМЬСГАЛЫН САНХҮҮЖИЛТИЙН МЕХАНИЗМЫГ АШИГЛАХ

Дэлхийн санхүүгийн байгууллагууд (жишээ нь, ОУСК, Европын сэргээн босголт, хөгжлийн банк) дуудлага худалдааны зураг төсөл, төслийн бэлтгэл, санхүүжилтийг дэмжих замаар Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг идэвхтэй дэмжиж байна.

- Олон улсын хөрөнгө оруулалтын стандартад нийцсэн, санхүүжүүлэх боломжтой төслүүдийг бүтцэд оруулах чиглэлд олон талт хөгжлийн банкуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх.
- Сэргээгдэх эрчим хүчний хөгжүүлэлтийн эхний шатандаа байгаа төслүүдийн эрсдэлийг багасгах болон тэдгээрт хувийн хөрөнгийг татах зорилгоор холимог санхүүжилт болон баталгааны механизмыг ашиглах.
- Хөрөнгийн өртгийг бууруулах зорилгоор Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалттай холбоотой нүүрстөрөгчийн үнийн болон ногоон бондын зах зээлд нэвтрэх боломжийг судлах.

Олон улсын санхүүгийн хэрэгслүүд нь дотоодын санхүүжилтийн чадавхийн дутууг нөхөж, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг хурдасгах боломжтой.

8. ТАРИФЫН БОЛОН БОДЛОГЫН РЕФОРМЫГ ЭДИЙН ЗАСГИЙН ИЛҮҮ ӨРГӨН ХҮРЭЭТЭЙ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДУУЛАХ

Сэргээгдэх эрчим хүчний реформыг урт хугацааны стратегийн зорилтуудтай уялдуулах нь Монгол Улсын эдийн засаг, уур амьсгалын хүрээний зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болно.

- Тарифын реформыг Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Сэргээгдэх эрчим хүчний 2030 оны хүртэлх зорилтууд болон Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтуудтай уялдуулах.
- Ногоон хөрөнгө оруулалтын харилцан хөшүүргийг бэхжүүлэх зорилгоор салбар дундын бодлогын уялдаа холбоог (эрчим хүч, аж үйлдвэр, уур амьсгал) хангах.
- Ногоон устөрөгч зэрэг шинээр гарч ирж буй салбаруудын төлөвлөлтийг тариф болон сүлжээний стратегийн хүрээнд нэгтгэх.

Бодлогын уялдаа холбоо хангах нь уян хатан ажиллах боломжийг нэмэгдүүлдэг бөгөөд реформ нь эдийн засаг, байгаль орчин, эрчим хүчний аюулгүй байдлын зорилтуудын хэрэгжилтийг нэмэгдүүлнэ.

